

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2023/14/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр аймаг

2023 он

Дарга тэргүүлэх аудитор:

Утас: 7054-3179

Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:

Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:

Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ГСА	Говьсүмбэр аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: govsumben@audit.gov.mn

**АЙМГИЙН "ЦАГДААГИЙН ХЭЛТЭС"-  
ИЙН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
Ц.БАЯРХҮҮ ТАНАА**

2023.08.17 № 04

танай \_\_\_\_\_-ныг № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус сан нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020013

## Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилт шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн 5 зорилтын хүрээнд 67 арга хэмжээ бүхий байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж 92 хувьтай тайлагнасан байна. ТЭЗ-аас гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг дүгнэж ирүүлээгүй байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу, илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>254,180,272.30</b>	<b>284,313,098.65</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>9,317,240.00</b>	<b>11,992,240.00</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>9,317,240.00</b>	<b>11,992,240.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>9,317,240.00</b>	<b>11,992,240.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	9,317,240.00	11,992,240.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>41,379.00</b>	<b>542,543.84</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>244,821,653.30</b>	<b>271,778,314.81</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>158,813,481.86</b>	<b>168,061,570.12</b>
35110	Тусгай зориулалттай материал	144,655,987.22	151,745,160.12
35130	Эм боох материал	14,157,494.64	16,316,410.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>86,008,171.44</b>	<b>103,716,744.69</b>
35410	Бичиг хэргийн материал	8,646,460.00	10,647,953.00
35420	Аж ахуйн материал	18,465,007.73	21,551,068.73
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	1,422,600.00
35440	Түлш, шатах тослох материал	5,692,386.00	5,372,211.00
35450	Барилгын засварын материал	9,766,150.00	8,469,650.00
35460	Хүнсний материал	45,606.75	6,963,477.00
35470	Бусад хангамжийн материал	43,392,560.96	49,289,784.96
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,207,343,756.76</b>	<b>4,854,974,521.13</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,207,343,756.76</b>	<b>4,854,974,521.13</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,605,797,523.51</b>	<b>4,259,337,921.25</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,500,020,844.61	4,217,746,864.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-257,549,429.54	-309,417,825.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,264,952.52	254,124,786.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	-99,230,808.57	-138,866,562.59
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	649,767,530.92	621,363,562.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-467,243,967.86	-462,381,342.26
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,102,445.90	74,401,338.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	-55,701,500.47	-29,000,357.10
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	31,367,456.00	31,367,456.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>601,546,233.25</b>	<b>595,636,599.88</b>
39301	Програм хангамж	28,906,500.00	28,906,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-11,994,266.75	-17,903,900.12
39303	Бусад биет бус хөрөнгө	584,634,000.00	584,634,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,461,524,029.06</b>	<b>5,139,287,619.78</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,461,524,029.06</b>	<b>5,139,287,619.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,461,524,029.06</b>	<b>5,139,287,619.78</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,066,748,160.11	1,066,748,160.11
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,066,748,160.11	1,066,748,160.11
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>520,843,655.95</b>	<b>3,322,462,821.28</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	208,726,795.11	644,699,230.56
51220	Тайлант үеийн үр дүн	312,116,860.84	2,677,763,590.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,932,213.00	750,076,638.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,461,524,029.06</b>	<b>5,139,287,619.78</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,136,615,918.13</b>	<b>4,699,532,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>469,139,718.13</b>	<b>2,941,963,676.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>469,139,718.13</b>	<b>2,941,963,676.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>51,071,828.00</b>	<b>21,033,260.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,817,750.00	8,841,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,181,578.00	1,808,265.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,072,500.00	10,383,895.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	396,723,634.16	2,911,062,148.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,344,255.97	9,868,268.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,667,476,200.00</b>	<b>1,757,568,324.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,610,615,500.00</b>	<b>1,747,938,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,610,615,500.00	1,747,938,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>56,860,700.00</b>	<b>9,630,024.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,089,800.00	50,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,770,900.00	9,580,024.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,824,474,857.29</b>	<b>1,937,763,773.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,824,474,857.29</b>	<b>1,937,763,773.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,815,117,547.29</b>	<b>1,903,879,606.61</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,279,111,316.00</b>	<b>1,344,911,302.16</b>
210101	Үндсэн цалин	729,454,816.00	737,649,361.00
210102	Нэмэгдэл	549,656,500.00	551,508,227.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	17,120,070.00
210104	Урамшуулал	0	35,016,817.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	3,616,827.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,232,523.00</b>	<b>31,009,616.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,997,153.00	2,385,509.79
210202	Тэтгэмжийн даатгал	266,039.00	261,141.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	332,548.00	244,023.24
210204	Ажилгүйдлийн даатгал	48,451.00	27,280.02
210205	Эрүүл мэндийн даатгал	25,588,332.00	28,091,661.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>95,677,941.00</b>	<b>162,716,189.10</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,234,100.00	17,262,028.10
210302	Түлш, халаалт	75,507,641.00	141,585,441.00
210303	Цэвэр, бохир ус	3,936,200.00	3,868,720.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>113,124,757.00</b>	<b>94,950,030.00</b>
210401	Бичиг хэрэг	8,817,510.00	12,608,065.00
210402	Тээвэр, шатахуун	78,546,990.00	71,978,075.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,802,200.00	8,219,790.00
210404	Ном, хэвлэл	105,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	190,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,908,500.00	1,814,100.00
210408	Бараа материал акталсны зардал	12,754,557.00	0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>28,913,182.61</b>	<b>15,045,489.39</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,146,679.36	3,100,864.64
210502	Хоол, хунс	21,766,503.25	11,944,624.75

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	900,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,459,850.00</b>	<b>19,125,500.00</b>
210604	Урсгал засвар	12,459,850.00	19,125,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,994,000.00</b>	<b>10,714,100.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,994,000.00	10,714,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,080,704.00</b>	<b>5,548,320.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,365,940.00	3,530,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	667,000.00	628,444.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	308,000.00	312,356.00
210807	Газрын төлбөр	591,156.00	767,100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	148,608.00	310,420.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>238,523,273.68</b>	<b>218,968,059.96</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,641,600.00	6,708,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,060,000.00	3,253,517.10
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	235,821,673.68	209,006,142.86
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>9,357,310.00</b>	<b>33,884,166.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,740,000.00</b>	<b>4,831,068.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	941,068.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,240,000.00	3,890,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,817,750.00</b>	<b>29,053,098.90</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,817,750.00	29,053,098.90
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,799,560.00</b>	<b>0</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,799,560.00	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>312,141,060.84</b>	<b>2,761,768,226.49</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>24,200.00</b>	<b>84,004,635.77</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0	778,604.82
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	83,226,030.95
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	24,200.00	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>312,116,860.84</b>	<b>2,677,763,590.72</b>



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,687,611,190.00</b>	<b>1,773,065,424.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>20,134,990.00</b>	<b>15,497,100.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>20,134,990.00</b>	<b>15,497,100.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>20,134,990.00</b>	<b>15,497,100.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,817,750.00	8,841,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,317,240.00	6,656,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,667,476,200.00</b>	<b>1,757,568,324.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,610,615,500.00</b>	<b>1,747,938,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,610,615,500.00	1,747,938,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>56,860,700.00</b>	<b>9,630,024.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,089,800.00	50,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,770,900.00	9,580,024.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,591,028,550.00</b>	<b>1,750,750,924.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,591,028,550.00</b>	<b>1,750,750,924.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,584,470,800.00</b>	<b>1,710,210,757.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,275,647,182.00</b>	<b>1,343,720,104.00</b>
210101	Үндсэн цалин	725,950,682.00	782,418,382.00
210102	Нэмэгдэл	549,696,500.00	506,584,550.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	17,120,070.00
210104	Урамшуулал	0	33,980,275.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	3,616,827.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>29,332,600.00</b>	<b>31,018,670.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	0	2,385,510.50
210202	Тэтгэмжийн даатгал	0	280,647.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	224,517.91
210204	Ажилгүйдлийн даатгал	0	34,361.27
210205	Эрүүл мэндийн даатгал	29,332,600.00	28,093,632.92
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>97,381,900.00</b>	<b>162,846,189.10</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,234,100.00	17,262,028.10
210302	Түлш, халаалт	77,211,600.00	142,093,324.00
210303	Цэвэр, бохир ус	3,936,200.00	3,490,837.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>97,867,000.00</b>	<b>100,625,590.00</b>
210401	Бичиг хэрэг	10,993,000.00	14,589,900.00
210402	Тээвэр, шатахуун	73,686,000.00	71,339,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,108,000.00	8,219,790.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	330,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	6,146,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,665,000.00</b>	<b>19,591,200.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,500,000.00	1,289,500.00
210502	Хоол, хүнс	21,665,000.00	16,925,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,376,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>36,505,218.00</b>	<b>24,247,604.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,375,218.00	260,524.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	2,769,780.00
210604	Урсгал засвар	24,130,000.00	21,217,300.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>7,994,000.00</b>	<b>10,714,100.00</b>

210702	Дотоод албан томилолт	7,994,000.00	10,714,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,936,300.00</b>	<b>10,061,300.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,166,300.00	8,353,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	667,000.00	643,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	308,000.00	297,200.00
210807	Газрын төлбөр	795,000.00	767,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,141,600.00</b>	<b>7,386,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,641,600.00	3,981,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	3,405,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,557,750.00</b>	<b>40,540,166.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,740,000.00</b>	<b>11,487,068.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	6,539,568.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,240,000.00	4,947,500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,817,750.00</b>	<b>29,053,098.90</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,817,750.00	29,053,098.90
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>96,582,640.00</b>	<b>22,314,500.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>88,907,000.00</b>	<b>19,639,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>88,907,000.00</b>	<b>19,639,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>88,907,000.00</b>	<b>19,639,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	88,907,000.00	19,639,500.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-88,907,000.00</b>	<b>-19,639,500.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>7,675,640.00</b>	<b>2,675,000.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,641,600.00	9,317,240.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,317,240.00	11,992,240.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,066,748,160.11	873,932,213.00	213,826,795.11	2,154,507,168.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-5,100,000.00	-5,100,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,066,748,160.11	873,932,213.00	208,726,795.11	2,149,407,168.22
4	Тайлант үеийн үр дүн	0	0	312,116,860.84	312,116,860.84
5	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,066,748,160.11	873,932,213.00	520,843,655.95	2,461,524,029.06
6	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,066,748,160.11	873,932,213.00	520,843,655.95	2,461,524,029.06
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	123,855,574.61	123,855,574.61
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,066,748,160.11	873,932,213.00	644,699,230.56	2,585,379,603.67
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	123,855,574.61	0	-123,855,574.61
10	Тайлант үеийн үр дүн	0	0	2,677,763,590.72	2,677,763,590.72
11	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,066,748,160.11	750,076,638.39	3,322,462,821.28	5,139,287,619.78

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,754,938,300.00</b>	<b>1,727,726,301.10</b>	<b>27,211,998.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,754,938,300.00</b>	<b>1,727,726,301.10</b>	<b>27,211,998.90</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,741,904,800.00</b>	<b>1,716,289,233.10</b>	<b>25,615,566.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,344,354,800.00</b>	<b>1,343,720,104.00</b>	<b>634,696.00</b>
210101	Үндсэн цалин	770,334,800.00	782,418,382.00	-12,083,582.00
210102	Нэмэгдэл	544,020,000.00	506,584,550.00	37,435,450.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,000,000.00	17,120,070.00	-2,120,070.00
210104	Урамшуулал	15,000,000.00	33,980,275.00	-18,980,275.00
210105	Гэрээт ажлын хөлс	0	3,616,827.00	-3,616,827.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>31,035,800.00</b>	<b>31,018,670.00</b>	<b>17,130.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	0	2,385,510.50	-2,385,510.50
210202	Тэтгэмжийн даатгал	0	280,647.40	-280,647.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	224,517.91	-224,517.91
210204	Ажилгүйдлийн даатгал	0	34,361.27	-34,361.27
210205	Эрүүл мэндийн даатгал	31,035,800.00	28,093,632.92	2,942,167.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>167,139,300.00</b>	<b>162,846,189.10</b>	<b>4,293,110.90</b>
210301	Гэрэл, цахилгаан	19,976,600.00	17,262,028.10	2,714,571.90
210302	Түлш, халаалт	143,410,200.00	142,093,324.00	1,316,876.00
210303	Цэвэр, бохир ус	3,752,500.00	3,490,837.00	261,663.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>101,773,900.00</b>	<b>100,415,590.00</b>	<b>1,358,310.00</b>
210401	Бичиг хэрэг	19,379,900.00	14,379,900.00	5,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	66,661,500.00	71,339,900.00	-4,678,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,949,600.00	8,219,790.00	729,810.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	636,900.00	330,000.00	306,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,146,000.00	6,146,000.00	0.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,144,700.00</b>	<b>19,591,200.00</b>	<b>553,500.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,289,500.00	1,289,500.00	0.00
210502	Хоол, хунс	17,425,200.00	16,925,200.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,430,000.00	1,376,500.00	53,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>38,257,300.00</b>	<b>37,517,080.00</b>	<b>740,220.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,300,000.00	13,650,000.00	650,000.00
210602	Тавилга	0	0	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,860,000.00	2,769,780.00	90,220.00
210604	Урсгал засвар	21,097,300.00	21,097,300.00	0.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>10,807,800.00</b>	<b>10,714,100.00</b>	<b>93,700.00</b>
210701	Гадаад албан томилолт	0	0	0.00
210702	Дотоод албан томилолт	10,807,800.00	10,714,100.00	93,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	0	0.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,007,900.00</b>	<b>10,061,300.00</b>	<b>15,946,600.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,300,000.00	8,353,400.00	15,946,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	643,600.00	643,600.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	297,200.00	297,200.00	0.00
210807	Газрын төлбөр	767,100.00	767,100.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,383,300.00</b>	<b>405,000.00</b>	<b>1,978,300.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,383,300.00	405,000.00	1,978,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,033,500.00</b>	<b>11,437,068.00</b>	<b>1,596,432.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,033,500.00</b>	<b>11,437,068.00</b>	<b>1,596,432.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,086,000.00	6,489,568.00	1,596,432.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,947,500.00	4,947,500.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,754,938,300.00</b>	<b>1,727,726,301.10</b>	<b>27,211,998.90</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,747,938,300.00</b>	<b>1,718,885,201.10</b>	<b>29,053,098.90</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,747,938,300.00	1,718,885,201.10	29,053,098.90
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>7,000,000.00</b>	<b>8,841,100.00</b>	<b>-1,841,100.00</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,000,000.00	8,841,100.00	-1,841,100.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>173</b>	<b>165</b>	<b>8</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>86</b>	<b>82</b>	<b>4</b>
620001	Удирдах ажилтан	2	2	0
620002	Гүйцэтгэх ажилтан	79	75	4
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>86</b>	<b>82</b>	<b>4</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	0	0	0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	81	77	4
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>9,630,024.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,630,024.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>9,580,024.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>210,000.00</b>
210401	Бичиг хэрэг	210,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,370,024.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,250,024.00
210604	Урсгал засвар	120,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,000,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>50,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	50,000.00

I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>9,630,024.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>9,630,024.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,580,024.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн үндсэн чиг үүрэг нь Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах бөгөөд 2022 онд салбарын хэмжээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

- "Хүний эрхийг дээдлэн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэт технологийн ашиглалтыг нэмэгдүүлнэ."
- "Алба хаагчдын эрүүл мэнд хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлж ажиллана"

Дээрх зорилтын хүрээнд ТЕЗ-тай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт 67 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 92%-тай тайлагнажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэст дотоод аудитын чиг үүрэг бүхий бүтэц байхгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Говьсүмбэр аймгийн хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2013 оны 422 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомжийг өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн батлах шаардлагатай байна.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,677,763.7 мянган төгрөгөөр буюу 1.08 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт

Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,317.2	11,992.2	2,675.0
Авлага	41.4	542.5	501.2
Бараа материал	244,821.7	271,778.3	26,956.7
Үндсэн хөрөнгө	2,207,343.8	4,854,974.5	2,647,630.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,461,524.0</b>	<b>5,139,287.6</b>	<b>2,677,763.6</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,461,524.0	5,139,287.6	2,677,763.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,461,524.0</b>	<b>5,139,287.6</b>	<b>2,677,763.6</b>

Дээрх хүснэгтээс харахад бараа материал, үндсэн хөрөнгө засгийн газрын хувь оролцоо дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,675.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн данснаас 6,656.0 мянган төгрөгийг ахмадын сангийн харилцах дансанд шилжүүлж, 3,981.0 мянган төгрөгийг зарцуулсан тул үлдэгдэл 2,675.0 мянган төгрөгийг тайлагнажээ.
2. Авлага дансны үлдэгдэл 501.2 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын илүү төлөлт үүссэнтэй холбоотой байна.
3. Бараа материал дансны үлдэгдэл 26,956.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дараах бараа материалын дансанд орсон материаллаг өөрчлөлттэй холбоотой байна.
  - Тусгай зориулалтын материалын дансанд ЦЕГ-аас 7,277.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал хүлээн авсан, бусад хангамжийн материалын дансанд 5,897.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, ЦЕГ-ын 2022.12.09 өдрийн 14/1772 тоот албан бичгээр бичгийн дагуу бичиг хэрэг, хоол хүнс, шатахууны худалдан авч үлдэгдлээр тайлагнасан нь нөлөөлжээ.
4. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,647,630.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,786,299.2 мянга, үндсэн хөрөнгийн сайжруулалтаар 36,001.3 мянган төгрөгийн барилга байгууламж, ЦЕГ-аас 20,781.8 мянга, аймгийн ИТХ-аас 7,120.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, Сүмбэр сумын ЗДТГ-аас 25,000.0 мянга, аймгийн ИТХ-аас 20,000.0 мянга, Шивээговь сумын ЗДТГ-аас 15,859.8 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, хөрөнгийн ашиглах жил, дансны үнийг шинэчлэн тогтоосон 9,939.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж нийт 2,921,002.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого бүртгэж төсвийн хөрөнгөөр 19,639.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авч нийт 2,940,641.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс аймгийн ИТХ-ын 2022 оны 05-р тогтоолоор 104,574.5 мянган төгрөгийн цагдаагийн хэлтсийн хуучин барилгыг Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлсэн, аймгийн ИТХ-ын 2022 оны 135-р захирамжийн 15-р хавсралтын дагуу 102,479.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн акталж устгасан, 20,107.1 мянган төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгийн ашиглах жил, дансны үнийг шинэчлэн тогтоох зорилгоор данснаас хассан, 209,006.1 мянган төгрөгийн элэгдэл бүртгэсэнтэй холбоотой байна.
5. Засгийн газрын хувь оролцоо данс өмнөх оноос 2,677,763.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,305,290.8 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого 7,000.0 мянга, нийт 2,312,290.8 мянга, зарлагыг 2,312,290.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.



Төсвийн төслийн саналаас орлого, зардлыг 585,322.0 зардлыг мянган төгрөгөөр бууруулж, оны эхэнд 1,726,968.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 27,969.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж жилийн эцэст 1,754,938.3 мянган төгрөг болгож тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70708 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,637,698.5 мянга, 80802 арга хэмжээг санхүүжүүлэхээр 13,033.5, мянга, 82315 арга хэмжээг санхүүжүүлэхээр 10,000.0 мянга, 70711 хөтөлбөрийн 80101 арга хэмжээг санхүүжүүлэхээр 94,206.3 мянга төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,754.938.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,727,726.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 7,164.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70704-80101	1,637,698.5	1,623,884.1	13,814.4	99.15%
2	70704-80802	13,033.5	11,437.1	1,596.4	87.75%
3	70704- 82315	10,000.0	2,387.4	7,612.6	23.87%
4	70711-80101	94,206.3	90,017.7	4,188.6	95.55%
	<b>Нийт</b>	<b>1,754,938.4</b>	<b>1,727,726.3</b>	<b>27,212.0</b>	<b>98.45%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон нэмэлт орлого 9,580.0 мянга, цахим тендерийн хураамж 50.0 мянга, нийт 9,630.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34/314 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүн 1,824,474.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 27,367.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цахилгааны эрчим хүчний зардлыг батлагдсан төсвөөс 14 хувь буюу 2,714.6 мянга, түлш халаалт, цэвэр бохир усны зардлыг 4 хувь буюу 1,578.5 мянган төгрөгөөр хэмнэлт гаргажээ.

Бичиг хэргийн зардлын хувьд 2021 онд 49 хэвлэгчийн хор, 98 цэнэглэгч хор, 296 бичгийн цаасыг зарцуулж байсан бол 2022 онд 46 хэвлэгчийн хор, 33 цэнэглэгч хор, 436 бичгийн цаас зарцуулсан байна. Бичиг хэргийн зардал өмнөх оноос 3.700.0 мянган төгрөгөөр өсөж зардал хэмнэгдээгүй байна. Энэ нь ЦЕГ-ын 2022 оны 14/1772 тоот албан бичгийн дагуу бичиг хэрэг, хоол хүнс, тээвэр шатахууны зардлыг зориулалтын дагуу зарцуулж, худалдан авалтыг хийх чиглэл ирсэнтэй холбоотой байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс нь 11 бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан 296,534.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний санхүүжилтээс 25,115.2 мянган төгрөгийг дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т заасныг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим хуудсанд дутуу мэдээлсэн 25,115.2 мянган төгрөгийн 8 нийлүүлэгчид олгосон санхүүжилтийг нөхөн мэдээлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны эхний 3-р улирлын байдлаар хийсэн завсарын аудитаар өгсөн 1,933.8 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	320.3	1	320.3	100%
Албан шаардлага	3	47,993.4	3	47,993.4	80%
Зөвлөмж					
Нийт дүн	4	48,313.7	4	48,313.7	90%

Өмнөх аудитаар 48,313.7 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, 47,993.4 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 320.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг хянаж үзэхэд албан шаардлага 80% , төлбөрийн акт 100% хэрэгжсэн байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 8,044.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 4,011.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,422.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж, 2,610.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өглөө. Үүнд:

### **Залруулсан алдаа:**

1. Мөнгөн гүйлгээний тайланд 260.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан гүйлгээг хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2006 оны 388-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 6 дугаар зүйлийн 6.9, 6.10 дахь заалт, УСНББОУС-2-25А-т заасныг зөрчсөн.
2. Санхүүгийн үр дүнгийн тайланд 2,734.0 мянган төгрөгийн цалин хөлсний зардлыг хоол хүнсний зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар", УСНББОУС-39-9а-д заасныг зөрчсөн.
3. 3-р улирлын санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1,017.2 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэснийг завсрын аудитаар залруулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалт, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

### **5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.**

### **5.2 Албан шаардлага**

5.2.1. Үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

#### **Илрүүлэлт:**

Аймгийн ИТХ-ын ГХУС арга хэмжээний зардлаас Пробокс маркын автомашинтай хамт хүлээлгэж өгсөн маяк-дуут дохио, богино долгионы станцыг байгууллагын хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

**Шийдвэрлэлт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас олгосон дуут дохио, богино долгионы станцыг байгууллагын данс бүртгэлд бүртгэж тайлагнах

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Бараа материалын бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

#### **Илрүүлэлт:**

Тээвэр шатахууны зардлын худалдан авалтад олгох 1,422.9 мянган төгрөгийн урамшууллыг авлага үүсгэж бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, "Содмонгол групп" ХХК-тай байгуулсан гэрээний 2-р зүйлийг зөрчсөн.

#### **Өгсөн зөвлөмж:**

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Гэрээний дагуу нийлүүлэгч байгууллагаас олгох урамшууллыг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнах

5.3.2. Үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 48 нэр төрлийн 142 ширхэг үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой 367,147.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэлж бүртгээгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 5.1.5, 20.2.4, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 7.1-т заасныг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Ашиглалтын хугацаа дууссан 367,147.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн акталж, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг үнэлж данс бүртгэлд бүртгэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайланд бараа материал худалдан авсан гүйлгээг хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр тайлагнасан.	1	260.5			1	260.5	1	260.5				
Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлсний зардлыг хоол хүнсний зардлаар тайлагнасан	1	2,734.0			1	2,734.0	1	2,734.0				
Санхүүгийн тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажгаагүй өр төлбөр бүртгэсэн.	1	1,017.2			1	1,017.2	1	1,017.2				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>4,011.7</b>			<b>3</b>	<b>4,011.7</b>	<b>3</b>	<b>4,011.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тэвээр шатахууны зардлын худалдан авалтад олгох урамшууллыг авлага үүсгэж бүртгээгүй.	1	1,422.9										
Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 48 нэр төрлийн 142 ширхэг үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой 367,147.1 мянган	1	0					1	1,422.9				

төгрөгийн хөрөнгийг үнэлж бүртгээгүй.													
Аймгийн ИТХ-ын ГХУС арга хэмжээний зардлаас Пробокс маркын автомашинтай хамт хүлээлгэж өгсөн маяк-дуут дохио, богино долгионы станцыг байгууллагын хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй.	1	2,640.0								1	2,640.0		
<b>Нийт</b>	<b>3</b>	<b>4,032.9</b>								<b>3</b>	<b>4,032.9</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
8 бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан 296,500.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээнээс 25,117.2 мянган төгрөгийн гүйлгээг дулуу мэдээлсэн Дүн	1	25,117.2			1	25,117.2		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил	1	25,117.2			1	25,117.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>25,117.2</b>			<b>1</b>	<b>25,117.2</b>		
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>25,117.2</b>			<b>1</b>	<b>25,117.2</b>		

Байгууллагын нэр: Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс  
 Байгууллагын РД: 9018999

Аудитын код: ГСА-2023/43НА-СТА-ТШЗ  
 Аудитын нэр: Сөнхүүгийн тайлангийн аудит  
 Тайлант хугацаа: 2022.01.01-2022.12.31

2023.02.15

№	Ажил гүйцэтгэний ангил, дансны үндэсдэл, тодруулга	Ажил гүйцэтгэний ангил, дансны үндэсдэл, тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /Төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харфи, тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
									Албан тушаал	Овог нэр
A			3	4	5	6	7	8	9	10
<b>Сөнхүүгийн тайлангийн аудитын алдаа</b>										
1	Мөнгөн хөрөнгө	Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйцээ	Мөнгөн гүйцэтгэний тайланд бараа материал худалдан авсан гүйцээг хөрөнгө оруулалтын мөнгөн гүйцээгээр тайлагнасан.	260,524	Заглуула			Заглуула	Дарга Нэгтгэн Бодогч	Ц.Баярхүү Б.Гарамжанд
2	Зардал	Хоол хүнсний зардал	Сөнхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлсний зардлыг хоол хүнсний зардалаар тайлагнасан	2,794,044	Заглуула			Заглуула	Дарга Нэгтгэн Бодогч	Ц.Баярхүү Б.Гарамжанд
3	Өр төлбөр	Хувь хүмүүст төлөх өр	Сөнхүүгийн тайланд тосооо нийлсэн актаар баталгаажуулагүй өр төлбөр бүртгэсэн.	1,017,210	Заглуула			Заглуула	Дарга Нэгтгэн Бодогч	Ц.Баярхүү Б.Гарамжанд
<b>Алдааны дүн</b>				<b>4,011,778.0</b>						

<b>Сөнхүүгийн тайлангийн аудитын зөрчил</b>										
4	Орлого	Бараа материал	Тээвэр шатгаарууны зардлын худалдан авалтад олгох урамшууллыг авлага үүсгэж бүртгээгүй.	1,422,999	Зөвлөмж			Зөвлөмж	Дарга Нэгтгэн Бодогч	Ц.Баярхүү Б.Гарамжанд
5	Бараа материал	Хангамжийн материал	Аймгийн ИТХ-ын ГХУС арга хэмжээний зардлаас Пробокс маркын автомашинтай хамт худалдсан өгсөн марк-дууг дохио, болон долгионы станцыг байгууллагын хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй.	2,610,000	Албан шаардлага			Албан шаардлага	Дарга Нэгтгэн Бодогч	Ц.Баярхүү Б.Гарамжанд
6	Хөрөнгө	Үндсэн хөрөнгө	Ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртөө нөхсөн эдийн засгийн үр өгөөж хүртэж буй 48 нар төрлийн 142 ширхэг үндсэн хөрөнгөөс цаашид ашиглах боломжтой 367.1 сая төгрөгийн хөрөнгийг үнэлж бүртгээгүй.	-	Зөвлөмж			Зөвлөмж	Дарга Нэгтгэн Бодогч	Ц.Баярхүү Б.Гарамжанд
<b>Зөрчлийн дүн</b>				<b>4,032,999</b>						

<b>Сөнхүүгийн тайлангийн аудитаар шалтгаан нийцлийн аудитын асуудал</b>										
7	Хууль тогтоомжийн харгалзттай холбоотой асуудал	Шилэн дансмы тусгай хууль	8 бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан 296.5 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээгээс 25.1 сая төгрөгийн гүйцээг дуугуу мэдээлсэн.	25,117,197	Албан шаардлага			Албан шаардлага	Дарга Нэгтгэн Бодогч	Ц.Баярхүү Б.Гарамжанд
<b>Зөрчлийн дүн</b>				<b>25,117,197</b>						
<b>Нийт дүн</b>				<b>33,161,974</b>						

Бэлтгэсэн: Ахлах аудитор  
 Хянасан: Аудитын менежер  
 Хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор  
 Зөвшөөрсөн: Дарга  
 Зөвшөөрсөн: Нэгтгэн бодогч

Огноо: Б.Дарханбат  
 Огноо: Г.Наранбаяр  
 Огноо: Б.Сарангула  
 Огноо: Ц.Баярхүү  
 Огноо: Б.Гарамжанд





ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 07/А0860274  
ГТН-2023/14/НА-ТА-ТЦУЗ

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн аймгийн "Цагдаагийн хэлтэс"-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас Пробокс маркын автомашинтай хамт хүлээлгэж өгсөн маяк-дуут дохио, богино долгионы станцыг байгууллагын хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271-р тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас олгосон дуут дохио, богино долгионы станцыг байгууллагын данс бүртгэлд бүртгэж тайлагнах,

008040024

биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга хурандаа Ц.Баярхүү, нягтлан бодогч Б.Гарамханд нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АХЛАХ АУДИТОР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ДАРХАНБАТ

Б.САРАНТУЯА



<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас:70543179



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар

08/А0860274

ГСА-2023/43/НА-СТА-ТМЦ

Чойр

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн аймгийн "Цагдаагийн хэлтэс"-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан 296.5 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээнээс 25.1 сая төгрөгийн гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйл, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд дээрх зөрчлүүдийг арилган биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга хурандаа Ц.Баярхүү, нягтлан бодогч Б.Гарамханд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АХЛАХ АУДИТОР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ДАРХАНБАТ

Б.САРАНТУЯА



<sup>1</sup> Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Найрамдал хотхон, АЗДТГ-ын байр, Утас: 70543179

008040041